



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.20 № 3/258
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цөмийн энергийн комиссын ажлын албаны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Цөмийн энергийн комиссын ажлын алба нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.


Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Цөмийн энергийн комиссын ажлын албаны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЭНХЗАЯА





ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИССЫН АЖЛЫН АЛБАНЫ ТӨСВИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

YAG-ын САГ-ын дарга,
Тэргүүлэх аудитор С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг:
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: Ч.Болд
Утас: 261885
Цахим хаяг:
boldch@audit.gov.mn
Ахлах аудитор Ц.Цэрэнхүү
Аудитор: П.Цэнгүүн
Аудитор Р.Цолмон
Утас: 261885
Цахим хаяг:
tsenguunp@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: Үндэсний аудитын
газар
Байршил: Чингэлтэй дүүрэг
Цахим хуудас: www.audit.mn
2017 оны 2 дугаар сар

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Цөмийн энергийн комиссын ажлын албаны төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /САГ-2017/9/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Цөмийн энергийн комиссын ажлын албаны төсвийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Цөмийн энергийн комиссын ажлын албаны 2016 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 27-ноос 2017 оны 2 дугаар сарын 13-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын САГ-ын ОНАА-ы ахлах аудитор Ц.Цэрэнхүү, аудитор П.Цэнгүүн, аудитор Р.Цолмон нар хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Цөмийн энергийн комиссын ажлын албаны төсвийн 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 1 дүгээр сарын 24-нд Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Үндэсний аудитын газар аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 27-ноос 2017 оны 2 дугаар сарын 13-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд Цөмийн энергийн комиссын ажлын албаны удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Цөмийн энергийн комиссын ажлын алба нь үндсэн үйл ажиллагааны хүрээнд “Цөмийн энергийн тухай”, “Цөмийн зэвсгээс ангид байх тухай” зэрэг хуулиуд, санхүү, төсвийн талаарх үйл ажиллагаагааны хүрээнд Монгол улсын “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулиудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

ЗГ-ын 2015 оны 72 дугаар тогтоолоор батлагдсан “Цөмийн энергийн комиссын дүрэм”-д “Цөмийн энергийн комиссын зорилт нь цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, судалгааг хөгжүүлэх, цөмийн болон цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулахад оршино” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д “төсвийн бусад байгууллагын дарга тухайн байгууллагын төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Цөмийн энергийн комиссын ажлыг албаны дарга Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Цөмийн энергийн комиссын ажлын албаны төсвийн 2016 оны төсвийг Сангийн яамны төрийн сангаас олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Цөмийн энергийн комиссын ажлын албаны үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Цөмийн энцргийн комиссын ажлын албаны төсвийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын

уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 18-ыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Цөмийн энергийн комиссын ажлын албаны санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулсан боловч байгууллагын даргын тушаал шийдвэрээр баталгаажуулаагүй байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна. ОУ-ын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, нягтлан бодох бүртгэлийн програм нийцсэн байна.

Цөмийн энергийн комиссын ажлын албаны санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Цөмийн энергийн комиссын ажлын албаны санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Цөмийн энергийн комиссын ажлын албаны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед дунд гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт сул байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Цөмийн энергийн комиссын ажлын алба нь 2016 онд 1,317.0 сая төгрөгийн урсгал төсвийг зарцуулахаар төсвийн тодотголоор батлагдсан ч улсын төсвийн орлого бүрдүүлэлт хүндрэлтэй байгаагаас шалтгаалан 1,233.7 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж 83.3 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна. Үүнээс

бараа ажил үйлчилгээний зардал 826.9 сая төгрөг, урсгал шилжүүлгийн зардал 338.5 сая төгрөгийн тус тус гүйцэтгэлтэй ажилласан байна.

Шилэн дансны мэдээлэл

Тус газар нь “Шилэн дансны тухай” хуулийн дагуу өөрийн байгууллагын вэб сайтад шилэн данс цэсийг үүсгэн, www.shilendans.gov.mn сайттай холбож, уг цэсэнд байгууллагын 2017 оны батлагдсан төсөв, сар бүрийн төсвийн гүйцэтгэлийг тухай бүрт нь байршуулж байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 7 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 18 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Үйлчлүүлэгчээс авсан судалгаа, тоон мэдээлэл, тайлбар, тодорхойлолт, нотлох баримтуудыг санхүүгийн СТАУС програмд татаж хавсаргав.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Цөмийн энергийн комиссын ажлын албаны төсвийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа материал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, орлогын дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг бус хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. ЦЭКАА-ны үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 116.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө байгууллагын өөрийн эзэмшилд байхгүй байна. Үүний 24.8 сая төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж нь ЦЭГ татан буугдах үед халагдсан ажилтнууд нь компьютер тоног төхөөрөмжөө хүлээлгэж өгөөгүйгээс дутсан, үлдсэн 91.8 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг МХЕГ-т шилжүүлсэн боловч ТӨХ-ны тогтоол гараагүйн улмаас одоог хүртэл ЦЭКАА-ны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй байсаар байна. Мөн 2016 онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 10.2 сая төгрөгийн, ОУ-ын атомын энергийн агентлагийн Техникийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжиж буй “Дозиметрийн лабораторийн техникийн чадавхи, хүний нөөцийг бэхжүүлэх” МОН6/014 төслийн хүрээнд хүлээж авсан 716.0 сая төгрөгийн нийт 726.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэж аваагүй байна.

Шийдвэрлэсэн: Дутагдсан компьютер , тоног төхөөрөмжийг холбогдох хүмүүсээр төлүүлэх, МХЕГ-т шилжүүлсэн үндсэн хөрөнгийг ТӨБЗГ-аар тогтоол гаргуулж данс бүртгэлээс хасах, төсвийн хөрөнгөөр худалдаж авсан болон хандив тусламжаар хүлээж авсан үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаж авах талаар албан шаардлага өгөх.

2. 2016 оны жилийн эцэст бараа материалын тооллогыг хийгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1-т “Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг заавал хийнэ” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Бараа материалын тооллогыг хийж бараа материалын үлдэгдлийг баталгаажуулах талаар зөвлөмж өгөх.

3. Цацраг үүсгүүр болон цацраг идэвхт хаягдлыг хадгалалтад авах журам болон хадгалах үйлчилгээний төлбөрийн хэмжээг шинэчлэн батлаагүйн улмаас изотоп конторт цацраг үүсгүүр болон цацраг үүсгүүр бүхий тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хадгалснаар улсын төсөвт орлого төвлөрүүлэх боломжийг алдаж байна.

Шийдвэрлэсэн: Цацраг үүсгүүр болон цацраг идэвхт материалыг хадгалах журам, үйлчилгээний төлбөрийн хэмжээг шинэчлэн батлуулж ажиллах талаар зөвлөмж өгөх.

4. Байгууллагын дотоод хяналт түүний дотор санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт сул ажиллаж байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д “Төсвийн шууд захирагч нь дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах талаар зөвлөмж өгөх.

5. НББ-ийн бодлогын баримт бичгийг боловсруулсан боловч даргын тушаалаар батлаагүй хүчин төгөлдөр бус бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллаж байгаа нь НББ-ийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: НББ-ийн бодлогын баримт бичгийг байгууллагын даргын тушаалаар баталж, мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөх.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад залруулагдаагүй алдаа гараагүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Цөмийн энергийн комиссын ажлын албаны 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Цөмийн энергийн комиссын ажлын албаны төсвийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 926.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 842.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 83.4 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төсвийн захирагчийн төсвийн 2015 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас хийсэн аудитаар 1 зөвлөмж өгсөн бөгөөд бүрэн хэрэгжүүлсэн байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Цөмийн энергийн комиссын ажлын албаны төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.



ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИССЫН АЖЛЫН АЛБАНЫ 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1
Бараа материал.....2

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 2
Орлого.....3

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 1
Дотоод хяналт.....4

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 2
НББ-ийн бодлогын баримт
бичиг.....5

2017 оны 2 дугаар сар

2010 оны 3 дугаар сарын
01

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Цөмийн энергийн комиссын ажлын албаны удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг Төрийн аудитын байгууллагын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Цөмийн энергийн комиссын ажлын албаны дарга Г.Манлайжав, ахлах нягтлан бодогч Б.Долзодмаа болон санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Бараа материал	Тэргүүлэх ач холбогдол №1
----------------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

2016 оны жилийн эцэст бараа материалын тооллогыг хийгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1-т “Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг заавал хийнэ” гэж заасныг зөрчсөн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Бараа материалын тооллогыг хийж бараа материалын үлдэгдлийг баталгаажуулах.

Эрсдэлүүд

Бараа материал өөрийн эзэмшилд байхгүй байх

Бараа материал санхүүгийн тайланд бүрэн тусгагдаагүй байх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Асуудал 2: Орлого	Тэргүүлэх ач холбогдол №1
--------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Цацраг үүсгүүр болон цацраг идэвхт хаягдлыг хадгалалтад авах журам болон хадгалах үйлчилгээний төлбөрийн хэмжээг шинэчлэн батлаагүйн улмаас изотоп конторт цацраг үүсгүүр болон цацраг үүсгүүр бүхий тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хадгалснаар улсын төсөвт орлого төвлөрүүлэх боломжийг алдаж байна.

ҮАГ-ын зөвлөмж

Цацраг үүсгүүр болон цацраг идэвхт материалыг хадгалах журам, үйлчилгээний төлбөрийн хэмжээг шинэчлэн батлуулж, мөрдөж ажиллах.

Эрсдэлүүд

Орлогыг төсөвт төвлөрүүлээгүй байх

Өөрийн орлогыг бүртгээгүй байх, санхүүгийн тайланд зөрүүтэй тусгагдсан байх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Асуудал 1: Дотоод хяналт	Тэргүүлэх ач холбогдол №2
---------------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

1.Байгууллагын дотоод хяналт түүний дотор санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт сул ажиллаж байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д “Төсвийн шууд захирагч нь дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж заасныг зөрчсөн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах.

Эрсдэлүүд

Байгууллагын санхүүгийн удирдлага, хяналт, зохион байгуулалт сулрах.

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, орлого зарлагын гүйцэтгэл буруу илэрхийлэгдэх, төсвийг зориулалт бусаар зарцуулах

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Асуудал 2: НББ-ийн бодлогын баримт бичиг	Тэргүүлэх ач холбогдол №2
---	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

НББ-ийн бодлогын баримт бичгийг боловсруулсан боловч даргын тушаалаар батлаагүй хүчин төгөлдөр бус бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллаж байгаа нь НББ-ийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасныг зөрчсөн байна.

ҮАГ-ын зөвлөмж

НББ-ийн бодлогын баримт бичгийг байгууллагын даргын тушаалаар баталж, мөрдөж ажиллах.

Эрсдэлүүд

Дансны бичилт буруу хийсэн байх, дансны ангилал буруу байх, санхүүгийн тайлангууд буруу илэрхийлэгдэх.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	79,320,001.00	83,424,133.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	0.00
33	АВЛАГА	2,230,000.00	0.00
335	Бусад авлага	2,230,000.00	0.00
3351	Байгууллагаас авах авлага	2,230,000.00	
35	БАРАА МАТЕРИАЛ	77,090,001.00	83,424,133.00
351	Түүхий эд материал	145,200.00	8,426,119.55
35110	Тусгай зориулалттай материал	145,200.00	8,426,119.55
354	Хангамжийн материал	76,944,801.00	74,998,013.45
35410	Бичиг хэргийн материал	8,953,377.00	9,869,954.50
35420	Аж ахуйн материал	7,084,821.00	11,614,112.00
35440	Түлш, шатах тослох материал		2,008,029.95
35470	Бусад хангамжийн материал	60,906,603.00	51,505,917.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	568,773,733.10	502,484,573.84
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	568,773,733.10	502,484,573.84
392	Биет хөрөнгө	568,773,733.10	502,484,573.84
39201	Барилга, байгууламж, орон сууц	915,566,646.00	915,566,646.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(491,711,872.79)	(513,791,330.03)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	150,628,000.00	150,628,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(136,955,999.80)	(143,128,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	493,291,306.22	493,291,306.22
39206	Хуримтлагдсан элэгдэл	(424,942,214.16)	(444,342,845.22)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	137,776,123.90	137,776,123.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	(81,695,371.27)	(100,332,442.03)
39217	Ном	6,817,115.00	6,817,115.00
393	Биет бус хөрөнгө	0.00	0.00
39301	Програм хангамж	22,030,000.00	22,030,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(22,030,000.00)	(22,030,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	648,093,734.10	585,908,706.84
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	152,230,000.00	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	152,230,000.00	0.00
413	Өглөг	152,230,000.00	0.00
4136	Бусад өглөг	152,230,000.00	0.00
41361	Байгууллагад төлөх өглөг	152,230,000.00	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	495,863,734.10	585,908,706.84
51	Засгийн газрын хувь оролцоо	495,863,734.10	585,908,706.84
512	Хуримтлагдсан үр дүн	449,947,732.53	539,992,705.27
51210	Өмнөх үеийн үр дүн	449,947,732.53	449,947,732.53
51220	Тайлант үеийн үр дүн		90,044,972.74
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	45,916,001.57	45,916,001.57
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	648,093,734.10	585,908,706.84

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	974,772,920.00	1,260,329,336.95
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	28,306,330.00	26,663,861.95
120	Нийтлэг татварын бус орлого	27,514,330.00	17,903,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	27,514,330.00	17,903,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	27,514,330.00	17,903,000.00
122	Тусламжийн орлого	792,000.00	8,760,861.95
122001	Хандив тусламж /дотоод/	792,000.00	
122002	Хандив тусламж /гадаад/		8,760,861.95
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	946,466,590.00	1,233,665,475.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	946,466,590.00	1,233,665,475.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	946,466,590.00	1,233,665,475.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,324,466,370.83	1,170,284,364.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,324,466,370.83	1,170,284,364.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,082,969,964.38	745,632,056.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	285,756,258.09	378,269,385.16
210101	Үндсэн цалин	195,455,058.09	271,029,585.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,701,200.00	30,716,400.00
210105	Гэрээт ажлын хөлс	72,600,000.00	76,523,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,643,100.00	45,757,600.00
210201	Тэтгэврийн даатгал	18,985,860.00	26,478,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,531,448.00	3,026,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,164,310.00	7,930,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	632,862.00	756,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,328,620.00	7,565,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,351,880.00	40,086,885.00
210301	Гэрэл, цахилгаан	13,544,317.00	19,575,930.00
210302	Түлш, халаалт	8,751,631.00	9,054,162.00
210303	Цэвэр, бохир ус	2,107,932.00	1,496,793.00
210304	Байрны түрээс	10,948,000.00	9,960,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	96,217,947.46	48,911,555.21
210401	Бичиг хэрэг	9,634,669.00	10,991,012.50
210402	Тээвэр, шатахуун	1,921,600.00	8,505,310.05
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,904,262.46	11,587,835.26
210404	Ном, хэвлэл	2,674,897.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		1,851,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	69,082,519.00	15,975,497.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,021,756.00	12,739,410.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,113,250.00	10,272,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	908,506.00	66,810.00
210604	Урсгал засвар		2,400,000.00
2107	Томилолт, зочны зардал	22,914,251.00	29,012,410.10
210701	Гадаад албан томилолт	15,965,345.00	3,281,663.10
210702	Дотоод албан томилолт	780,500.00	1,790,900.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	6,168,406.00	23,939,847.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	473,260,422.00	122,551,152.02
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	464,839,235.00	104,873,457.02

210803	Даатгалын үйлчилгээ	2,561,267.00	3,619,575.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	401,800.00	401,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	38,800.00	50,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,419,320.00	4,403,320.00
210807	Газрын төлбөр		7,784,900.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		1,417,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	134,804,349.83	68,303,659.26
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,025,164.00	2,014,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	129,779,185.83	66,289,159.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	241,496,406.45	424,652,307.46
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	158,362,036.00	331,693,147.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	158,362,036.00	331,693,147.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,774,333.00	8,249,003.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,419,576.00	8,249,003.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	28,354,757.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	46,360,037.45	84,710,157.46
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	46,360,037.45	84,710,157.46
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(349,693,450.83)	90,044,972.74
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	70,408,276.87	0.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	70,408,276.87	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-70408276.87	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(420,101,727.70)	90,044,972.74

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	973,980,920.00	1,252,968,475.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	27,514,330.00	17,903,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	27,514,330.00	17,903,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	27,514,330.00	17,903,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	27,514,330.00	17,903,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	946,466,590.00	1,235,065,475.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	946,466,590.00	1,233,665,475.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	946,466,590.00	1,233,665,475.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	1,400,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		1,400,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	973,980,920.00	1,252,968,475.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	973,980,920.00	1,252,968,475.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	732,484,513.55	828,316,170.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	285,756,258.09	378,269,385.16
210101	Үндсэн цалин	195,455,058.09	271,029,585.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,701,200.00	30,716,400.00
210104	Урамшуулал		
210105	Гэрээт ажлын хөлс	72,600,000.00	76,523,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,643,100.00	45,757,600.00
210201	Тэтгэврийн даатгал	18,985,860.00	26,478,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,531,448.00	3,026,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,164,310.00	7,930,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	632,862.00	756,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,328,620.00	7,565,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,343,880.00	40,086,885.00
210301	Гэрэл, цахилгаан	13,536,317.00	19,575,930.00
210302	Түлш, халаалт	8,751,631.00	9,054,162.00
210303	Цэвэр, бохир ус	2,107,932.00	1,496,793.00
210304	Байрны түрээс	10,948,000.00	9,960,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,596,759.46	38,409,495.26
210401	Бичиг хэрэг	5,782,880.00	8,607,580.00
210402	Тээвэр, шатахуун	1,921,600.00	9,610,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,904,262.46	11,587,835.26
210404	Ном, хэвлэл	2,665,097.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		5,347,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,322,920.00	3,256,580.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,219,756.00	14,481,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,179,250.00	10,272,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,040,506.00	409,200.00
210604	Урсгал засвар		3,800,000.00
2107	Томилолт, зочны зардал	23,634,793.00	31,766,593.10
210701	Гадаад албан томилолт	15,965,345.00	3,281,663.10
210702	Дотоод албан томилолт	780,500.00	2,694,140.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	6,888,948.00	25,790,790.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	323,096,277.00	277,529,912.02
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	314,555,090.00	257,263,257.02
210803	Даатгалын үйлчилгээ	2,561,267.00	3,619,575.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	401,800.00	401,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	38,800.00	50,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,539,320.00	6,992,280.00
210807	Газрын төлбөр		7,784,900.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		1,417,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,193,690.00	2,014,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,193,690.00	2,014,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	241,496,406.45	424,652,304.46
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	158,362,036.00	330,293,147.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	158,362,036.00	330,293,147.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,774,333.00	8,249,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,419,576.00	8,249,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	28,354,757.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	46,360,037.45	86,110,157.46
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	46,360,037.45	86,110,157.46
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл		45,916,001.57	449,947,732.53		495,863,734.10
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	45,916,001.57	449,947,732.53	-	495,863,734.10
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн		45,916,001.57	449,947,732.53		495,863,734.10
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	45,916,001.57	449,947,732.53	0.00	495,863,734.10
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	45,916,001.57	449,947,732.53	0.00	495,863,734.10
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	45,916,001.57	449,947,732.53	0.00	495,863,734.10
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			90,044,972.74		90,044,972.74
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	45,916,001.57	539,992,705.27	0.00	585,908,706.84

АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,130,180,500.00	927,620,882.55	1,235,065,475.00	1,166,858,317.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,130,180,500.00	927,620,882.55	1,235,065,475.00	1,166,858,317.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	758,286,500.00	732,484,513.55	895,123,875.00	828,316,170.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	286,604,800.00	285,756,258.09	378,269,400.00	378,269,385.16
210101	Үндсэн цалин	196,303,600.00	195,455,058.09	271,029,600.00	271,029,585.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,701,200.00	17,701,200.00	30,716,400.00	30,716,400.00
210105	Гэрээт ажлын хөлс	72,600,000.00	72,600,000.00	76,523,400.00	76,523,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,643,100.00	31,643,100.00	45,757,600.00	45,757,600.00
210201	Тэтгэврийн даатгал	18,985,860.00	18,985,860.00	26,478,900.00	26,478,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,531,448.00	2,531,448.00	3,026,100.00	3,026,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,164,310.00	3,164,310.00	7,930,600.00	7,930,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	632,862.00	632,862.00	756,600.00	756,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,328,620.00	6,328,620.00	7,565,400.00	7,565,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,982,600.00	35,343,880.00	40,964,400.00	40,086,885.00
210301	Гэрэл, цахилгаан	13,634,100.00	13,536,317.00	18,735,100.00	19,575,930.00
210302	Түлш, халаалт	8,939,300.00	8,751,631.00	9,158,800.00	9,054,162.00
210303	Цэвэр, бохир ус	3,897,200.00	2,107,932.00	1,967,900.00	1,496,793.00
210304	Байрны түрээс	12,512,000.00	10,948,000.00	11,102,600.00	9,960,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,811,800.00	24,596,759.46	38,409,500.00	38,409,495.26
210401	Бичиг хэрэг	6,227,400.00	5,782,880.00	8,071,300.00	8,607,580.00
210402	Тээвэр, шатахуун	2,764,000.00	1,921,600.00	9,610,100.00	9,610,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,421,800.00	12,904,262.46	11,636,700.00	11,587,835.26
210404	Ном, хэвлэл	2,646,000.00	2,665,097.00		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал			6,800,800.00	5,347,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,752,600.00	1,322,920.00	2,290,600.00	3,256,580.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,275,500.00	3,219,756.00	14,362,700.00	14,481,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,230,000.00	2,179,250.00	9,171,800.00	10,272,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,045,500.00	1,040,506.00	1,390,900.00	409,200.00
210604	Урсгал засвар			3,800,000.00	3,800,000.00
2107	Томилолт, зочны зардал	26,458,300.00	23,634,793.00	31,766,600.00	31,766,593.10
210701	Гадаад албан томилолт	14,000,000.00	15,965,345.00		3,281,663.10
210702	Дотоод албан томилолт	5,121,200.00	780,500.00	5,253,800.00	2,694,140.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	7,337,100.00	6,888,948.00	26,512,800.00	25,790,790.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	338,710,400.00	323,096,277.00	343,579,175.00	277,529,912.02
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	334,807,900.00	314,555,090.00	320,120,075.00	257,263,257.02
210803	Даатгалын үйлчилгээ	2,561,300.00	2,561,267.00	3,619,600.00	3,619,575.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	401,800.00	401,800.00	464,600.00	401,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	10,800.00	38,800.00	140,000.00	50,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	928,600.00	5,539,320.00	10,000,000.00	6,992,280.00
210807	Газрын төлбөр			7,784,900.00	7,784,900.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж			1,450,000.00	1,417,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,800,000.00	5,193,690.00	2,014,500.00	2,014,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,800,000.00	5,193,690.00	2,014,500.00	2,014,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	371,894,000.00	195,136,369.00	339,941,600.00	338,542,147.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	331,266,300.00	158,362,036.00	330,295,000.00	330,293,147.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	331,266,300.00	158,362,036.00	330,295,000.00	330,293,147.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,627,700.00	36,774,333.00	9,646,600.00	8,249,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,164,300.00	8,419,576.00	9,646,600.00	8,249,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,463,400.00	28,354,757.00		
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	0.00	1,233,665,475.00	1,252,968,475.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.00	0.00	1,233,665,475.00	1,233,665,475.00
131001	Улсын төсвөөс санхүүжих			1,233,665,475.00	1,233,665,475.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.00	0.00	0.00	19,303,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих				19,303,000.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	0.00	0.00	45.00	42.00
620001	Удирдах ажилтан			1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан			32.00	29.00
620003	Үйлчлэх ажилтан				
620004	Гэрээт ажилтан			12.00	12.00